

ARD



Үндэслэл

Ард Санхүүгийн Нэгдэл нь Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилгынхоо хүрээнд санхүү, даатгал, хөрөнгийн зах зээл, технологи, дэд бүтэц, блокчэйн, хэвлэл мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулдаг 44 компанид хөрөнгө оруулж 60 мянга орчим хувьцаа эзэмшигчтэй болсон байна. Мөн бид блокчэйн технологийн хувьд Монголдоо анхдагч болж 2017 онд КriptoҮндэстэн Олон Улсын Чуулганыг зохион байгуулж, 2019 онд АрдКойн урамшууллын оноог танилцуулж, 2021 онд өөрийн Виртуал Хөрөнгийн Биржийн үйл ажиллагааг эхлүүлсэн.

Ард Санхүүгийн Нэгдлийн хувьд урамшууллын оноо болох АрдКойноор өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээг авах, хөнгөлүүлэх, хөрөнгө эзэмших боломжийг олгодгоос гадна экосистемийн компаниуд зах зээл дээрээс буцаан татах, харилцагч нарт давуу тал бүхий олон боломжийг санал болгож түүний тодорхой хэмжээг шатаалт хийж үнэ цэнийг нэмэгдүүлэхийг эрмэлздэг.

2021 онд крипто зах зээлийн өсөлттэй уялдуулан АрдКойн эзэмшигч, Ард Санхүүгийн Нэгдлийн харилцагчдадаа Виртуал Хөрөнгийн Биржийн үйл ажиллагаанаас ашиг хүртэх боломжийг АрдКойноор дамжуулан олгохоор боллоо.



Токен танилцуулга

idax.exchange нь Виртуал Хөрөнгийн Үйлчилгээ Үзүүлэгчээр бүртгэгдсэн виртуал хөрөнгийн арилжааны платформ юм. DAXT нь биржийн арилжааны шимтгэл болон бусад үйлчилгээний цэвэр ашгийн 30%-ийг улирал бүр тараах зорилготой токен юм. DAXT токеныг зөвхөн АрдКойноо хөрвүүлэн авах боломжтой.

| | |
|-----------------------|---|
| Токен гаргагч | Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Бит ХХК |
| Токен нэр | idax биржийн ашиг хуваалцах токен |
| Токен тикер | DAXT |
| Токен хэлбэр | Ашиг хуваалцах токен |
| Хөрвүүлэх нийт хэмжээ | DAXT 150,000,000 |
| Олборлолт | Олборлолт буюу майнинг хийх боломжгүй |
| Оролцох нөхцөл | Зөвхөн АрдКойноо хөрвүүлэн авах боломжтой |



Токен танилцуулга

idax.exchange нь Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө оруулалттай виртуал хөрөнгийн арилжааны платформыг ажиллуулдаг бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 14-нөөс эхлэн бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байна. idax нь олон улсын шилдэг блокчэйн платформуудын жишгээр арилжааг цахимаар явуулдаг ба крипто болон үнэт цаасны токеныг чөлөөтэй арилжаалах боломжийг олгодог. idax нь үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш давхардсан тоогоор нийт 860 мянга орчим харилцагч 3 их наяд гаруй төгрөгийн үнийн дүнтэй арилжаа хийсэн бөгөөд дараах төрлийн үйл ажиллагааг явуулдаг

- Виртуал хөрөнгө болон фиат мөнгөний арилжаа
- Виртуал хөрөнгө хоорондын арилжаа
- Виртуал хөрөнгийн шилжүүлэг
- Виртуал хөрөнгө эсвэл түүнд суурилсан санхүүгийн хэрэгслүүдийн удирдлага, хадгаламж
- Виртуал хөрөнгийг худалдах, худалдан авахтай холбоотой санхүүгийн үйлчилгээ



Токен танилцуулга

idax бирж нь 2021 оны арилжааны нийт хэмжээ ₮2.2 их наяд, 2022 онд ₮750 тэрбум байсан ба арилжааны шимтгэл 0.2% билээ.

Спот, Фьючерс, ETF, Маржин арилжаа хийх боломжтой бөгөөд OKX, Binance, Huobi биржүүдтэй Liquidity provider амжилттай холбогдож хослолуудын хөрвөх чадвар нэмэгдсэн. Нийт 20-иод төрлийн блокчейн сүлжээ дэмжих боломжтой монголын цор ганц бирж юм.

107,000+

Дотоод харилцагч

53,000+

Гадаад харилцагч

170+

Арилжааны хослол

20+

Блокчейн сүлжээ



Санал нөхцөл

| | |
|--------------------------------|--|
| Хөрвүүлэх боломжит дээд хэмжээ | DAXT 150,000,000 |
| Харьцаа | DAXT1=ARDX1 |
| Ногдол ашиг тараах хугацаа | Улирал бүр |
| Ногдол ашгийн хэмжээ | Цэвэр ашгийн 30 хувийг хувь тэнцүүлэн олгоно |

IDO захиалга

| | |
|---------------------------------|----------------------|
| Нэг хүний хөрвүүлэх дээд хэмжээ | 300,000 ARDX |
| Нэг хүний хөрвүүлэх доод хэмжээ | 3,000 ARDX |
| Захиалгын хугацаа | 2021 оны 12 сарын 31 |
| Хуваарилалтын арга | Хувь тэнцүүлэх |



Баталгаа

idax биржийн 100% өмчлөгч нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК болно.



Мэдэгдэл

Энэхүү танилцуулгад АрдКойн эзэмшигчдэд өөрийн АрдКойноо DAXT токен руу хөрвүүлэх шийдвэр гаргахад туслах шаардлагатай мэдээллийг агуулахыг зорьсон болно.

АрдКойноо хөрвүүлэх нь хөрөнгө оруулалтын нэг хэлбэр бөгөөд хөрвүүлэлт хийхээс өмнө үүсэж болох эрсдлийг сайтар судалж, бодит мэдлэг мэдээлэлд үндэслэн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахыг зөвлөж байна.